



**ХУУЛЬ ЗҮЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/28


Улаанбаатар хот

**Үнийг шинэчлэн тогтоох тухай**

Хууль зүйн хүрээлэнгийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтээр дагаж мөрдөх эрх зүйн захиргааны хэм хэмжээний актыг хавсралтын хамт бүрэн эхээр нь хэвлүүлэн гаргадаг. Хэвлэлийн зардал өссөнтэй холбогдуулан 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн эмхэтгэлийн нэг бүрийн үнийг 9,000 /есөн мянган/ төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.
2. Тус эмхэтгэлийг шинэчилсэн үнээр захиалгад оруулж, захиалагч байгууллагуудад мэдэгдэх, гэрээнд өөрчлөлт оруулах ажлыг Ахлах нягтлан бодогч /А.Батжаргал/-д даалгасугай.
3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга /Б.Баатарцогт/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Х.ЭРДЭМ-УНДРАХ